



13th Story

**Усан үзмийн талбайд
ажиллах ажилчныг олоорой**

Vineyard Parable

Усан үзмийн талбайд ажиллах ажилчныг олоорой!

– 13rd Story –

Есүс

Эрт цагт өргөн уудам газарт маш том усан үзмийн цэцэрлэгтэй газрын эзэн байжээ. Тэр үед ургац хураах үе болж ажилчин ч их хэрэгтэй болж гэнэ. Тэгээд усан үзмийн цэцэрлэгийн эзэн нэгэн өдрийн өглөө, өдөржин ажиллах ажилчин хайхаар гарчээ.

Усан үзмийн
цэцэрлэгийн эзэн

Ажилчид

уучлаарай өнөөдөр хийх ажлаа арай олоогүй байна уу?

тиймээ, хараахан олоогүй байна.

Эзэн

өө сайн юм боллоо. Өнөөдөр өдөржин манай усан үзмийн цэцэрлэгт ажиллавал ямар вэ?

Ажилчин 1

Хэр удаан ажиллавал болох вэ?

Эзэн

өдөржин

Ажилчин 2

өдөрт хэдийг өгөх вэ?

Эзэн

ердийн авдагтай яг адилхан өдрийн хөлс өгнө.

Ажилчин 1

Мм, өөр хийх ажил ч байхгүй юм чинь, яахав

Ажилчин 2

тийм ээ, бид хийе

Эзэн

за тохирлоо. Тэр өндөр толгод дээр байдаг том цэцэрлэг харагдаж байна уу?

Ажилчид

За ойлголоо

Эзэн

тэнд очиход л болно. Явцгаах уу?

Есүс

3 цаг өнгөрөөд усан үзмийн цэцэрлэгийн эзэн өөр олон ажилчид хайхаар гарч явав. Яагаад гэвэл цэцэрлэг нь үнэхээр том болохоор ажилчин дутжээ.

Эзэн

байзаарай, ажил хайж байна уу?

Ажилчид

тиймээ, хайж байна

Эзэн

Ашгүй дээ. Манай цэцэрлэгт очоод үлдсэн цагт ажиллаач. Ажлаа бүгдийг дуусгавал шударгаар өгье.

Ажилчид

за ойлголоо!

Есүс



Бас дахин 3 цаг өнгөрмөгц, усан үзмийн цэцэрлэгийн эзэн ажилчид хайхаар дахин гарчээ.

Эзэн

Хөөе, та нар ажил хайж байна уу?


Ажилчид

тиймээ, тэгээд л энд байна.





- Эзэн** өө сайн юм боллоо. Манай талбай руу явцгаая. Тэнд ажиллаж байгаа бусад ажилчидтай хамт дуустал нь ажиллая. Хөлсийг нь шударгаар өгье.
- Есүс** Эзэн ингэж хоёр удаа дахин гадагш гарч ажилчин хайв. Эзэнтэй уулзсан бүх ажилчдаас, эзэн өөрийн талбайд ажиллаач гэж асуусан.
- Эзэн** уучлаарай. Өдөржин энд ажил хайсан уу?
- Ажилчин** тийм ээ
- Эзэн** Тэгсэн ч юу ч хийж чадаагүй юу?
- Ажилчин** өдөржин, хэн ч биднээр ажил хийлгэсэнгүй.
- Эзэн** тийм үү? сайн юм болжээ. Манай цэцэрлэг рүү явцгаая. Бусад ажилчид хэдийнээ тэд ажиллаж байгаа. Тэнд дуустал нь хамт ажиллая. Хөлсийг нь шударгаар өгнө өө.
- Ажилчин** баярлалаа
- Есүс** Ажилчид ажлаа дуусч тийнхүү зовлонт өдөр дуусмагц цэцэрлэгийн эзэн ажилчдыг дуудав.
- Эзэн** Ажилчдыг дуудаж хөлсийг нь өгөөрэй. Миний хамгийн сүүлд ажиллуулсан ажилчдаас эхлээд хамгийн эхэнд ирсэн ажилчдын дарааллаар хөлсийг нь өгөөрэй.
- Зарц** За эзэнтээн
- Есүс** Зарц хамгийн сүүлд ирсэн хүнээс эхэлж хөлсийг нь өгчээ. Гэтэл хамгийн эхэнд ажиллахаар ирсэн ажилчин үүнийг хараад ихэд шантарч орхив.
- Эхэлж ирсэн ажилчид** Боль доо! Бид хамгийн эхэлж ирсэн. Биднээс эхэлж өгөх ёстой юм шиг байхын?
- Зарц** Би зүгээр л эхлээд өг гэж хэлсэн дарааллаар л өгч байна.
- Эхэлж ирсэн ажилчид** Яагаад биднээс эхэлж өгөхгүй гэж?
- Есүс** Зарц хамгийн сүүлд ирсэн ажилчдаас эхэнд ирсэн ажилчдад хүртэл хөлсийг нь бүгдийг өгчээ. Хамгийн эхэнд ирсэн ажилчид өөрсдийгөө хамгийн түрүүнд ирсэн учраас илүү ихийг авна гэж бодон найдаж байжээ. Гэтэл тэр зарц бүх ажилчдад яг адилхан хөлсийг нь өгч гэнэ. Эхэлж ирсэн ажилчид зарцаас хөлсөө авчихаад, тэд цэцэрлэгийн эзэнд ихэд уурлажээ.
- Эхэлж ирсэн ажилчид** энэ чинь юу болж байнаа? Бид халуун наранд өдөржин ажилласан шүү дээ!
- Эзэн** юу болоов? Ямар асуудал гараав?
- Эхэлж ирсэн ажилчид** үүнийг хар л даа! 1 цаг ажилласан хүмүүс ба өдөржин ажилласан бид яг адилхан мөнгө авсан байна.
- Эзэн** хөөе хөөе сайн бодоорой. Би та нарт буруу зүйл хийгээгүй. Өнөөдөр өглөө та нарыг хөлсөөр ажиллуулах үед та нар өдрийн хөлсөө зөвшөөрсөн, би тэр амлалтаа биелүүлсэн.



Эхэлж ирсэн
ажилчид

Эзэн

аа тийм хэдий ч ...

За тэгвэл болсон биз дээ? Тэгвэл та хувиа аваад яваарай.
Сүүлд ирсэн хүмүүст ч гэсэн та нартай яг адилхан хөлс
өгсөн. Тэр нь зөв зохистой. Бүх ажилчдад шударгаар
хандсан учир уурлах хэрэггүй.

Есүс

Энэ яриа нь тэнгэрийн хаанчлалын тухай яриа юм.
Бурхан тэнгэрүлсад ирсэн бүх хүнийг яг адилхан
хайрладаг. Сүүлчийнх нь эхнийх болж, эхнийх нь
сүүлчийнх байх болно. Дуудагдсан нэгэн олон боловч,
сонгогдсон нэгэн нь цөөн юм.